

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оныдугаар
сарын-ны өдөр

Дугаар....

Заавар шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг.“Даатгуулагчид малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр.Батлагдсан зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /С.Лхагвадорж/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах, лавлагаа болон тодорхойлолтын загвар батлах тухай” А/09 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА

Л.МӨНХЗУЛ

ДААТГУУЛАГЧИД МАЛЧНЫ НӨХЦӨЛӨӨР ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООХОД БАРИМТЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү зааврын зорилго нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу даатгуулагчийн малчнаар ажиллаж, шимтгэл төлсөнтэй холбоотой баримт бичгийг хянан баталгаажуулах, малчнаар ажилласан хугацааг тодорхойлох, тэтгэвэр тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтад зааснаар мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг “малчин” гэж ойлгоно.

1.3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу мал маллаж байсан малчин, саальчин, тууварчин (1990 оноос өмнөх тууварчинг хамааруулна), цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан, сайн дураар нийгмийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн малчин Монгол Улсын иргэн /цаашид “даатгуулагч” гэх/-ийг “малчин”-д хамааруулна.

Хоёр. Даатгуулагчийн малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг тодорхойлоход бүрдүүлэх баримт бичиг

2.1.Даатгуулагчийн 1995 оноос өмнө малчнаар ажилласан хугацааг тодорхойлоход дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

2.1.1.Хөдөлмөрийн дэвтэр;

2.1.2.Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр;

2.1.3.Хөдөлмөрийн дэвтэр эсхүл хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтрийн бичилт засвартай, буруу, зөрүүтэй бичигдсэн, үрэгдүүлсэн, хуулбарласан тохиолдолд ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай архивын лавлагаа эсхүл шүүхийн шийдвэр зэрэг болно.

2.2.Даатгуулагчийн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1990-1994 онд нөхөн тооцуулсан хугацааг малчнаар ажилласнаар тодорхойлоход дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

2.2.1.Хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацааны шимтгэлийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага нь Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай 1991 оны хуульд заасны дагуу нийт цалин хөлсний сангаас 13.5 хувиар тооцон тэтгэврийн даатгалын санд шимтгэл төлснийг нотолсон холбогдох Нийгмийн даатгалын газрын архивын лавлагаа;

2.2.2.Хувиараа мал маллаж байхдаа 1991 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 1994 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд сайн дураар нийгмийн даатгалд хамрагдаж, орлогоосоо 13.5 хувиар тооцон тэтгэврийн даатгалд шимтгэл төлснийг бүртгэсэн тооцооны хуудас;

2.2.3. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуульд хамрагдаж тэтгэврийн даатгалд даатгуулснаар нөхөн тооцуулсан “Баталгаажилтын хуудас”;

2.2.4. Мал маллан оршин сууж байсныг тодорхойлсон тухайн баг, хороо, эсхүл сумын Засаг даргын тодорхойлолт зэрэг болно.

2.3. Даатгуулагчийн 1995 он ба түүнээс хойш малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг тодорхойлоход дараах баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

2.3.1. Албан журмаар даатгуулсан бол малчнаар ажилд авсан, чөлөөлсөн тухай тушаал;

2.3.2. Малчнаар ажилласан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ;

2.3.3. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай байгуулсан сайн дурын даатгалын гэрээ;

2.3.4. Нийгмийн даатгалын дэвтэр эсхүл нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;

2.3.4. “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого”-ын жил бүрийн бүртгэл (цаашид “А” данс” гэх)-ийн лавлагаа;

2.3.5. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1995-2000 онд тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн “Баталгаажилтын хуудас”;

2.3.6. Шаардлагатай тохиолдолд гэрлэлтийн гэрчилгээ, лавлагаа эсхүл шүүхийн шийдвэр зэрэг болно.

Гурав. Даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тодорхойлох

3.1. Даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг доор дурдсанаар тодорхойлно. Үүнд:

3.1.1. 1968 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн эмэгтэй малчныг хуанлийн жилд 110, эрэгтэй малчныг 150 хоног ажилласан тохиолдолд нэг жил малчнаар ажилласнаар;

3.1.2. 1968 оны 01 дүгээр сарын 01-нээс 1991 он хүртэл хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн малчин (эмэгтэй, эрэгтэй)-ыг хуанлийн жилд 250 ба түүнээс дээш хоног ажилласан тохиолдолд нэг жил малчнаар ажилласнаар;

3.1.3. Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн малчин энэ зааврын 3.1.1, 3.1.2-т заасан хуанлийн жилд ажиллавал зохих хугацааг хангахгүй тохиолдолд малчнаар ажилласан нийт хоногийг нэгтгэн тооцож дүнг 30-д хувааж нийт ажилласан жил, сарыг тодорхойлно.

3.2. “А” дансанд “Малчин өрх”-өөр бүртгэгдсэн өрхийн гэр бүлийн гишүүнийг малчин гэж үзэн энэ зааврын 2 дахь хэсэгт заасан баримт бичгийг үндэслэн малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг тооцно.

Санамж¹. Тухайн малчин өрхийн малчдын тоог “А” дансны 11 дүгээр асуулгад тэмдэглэсэн “Малчдын тоо” хэсэгт бичигдсэнээр, харин тухайн малчны гэр бүлийн гишүүний мэдээллийг мөн дансны 2 дугаар бүлэг дэх “Малчдын мэдээлэл” хэсэгт бүртгэгдсэн хүний мэдээлэлтэй тулган шалгана. Энэ тохиолдолд малчин өрхийн эхнэр (нөхөр), 15 ба түүнээс дээш насны эцэг, эхээс өрх тусгаарлаагүй хүүхэд хамаарна.

Санамж². Малчин өрхийн тэргүүнтэй хамт амьдарсныг нотлох баримт бичиг (гэрлэлтийн гэрчилгээ, лавлагаа)-гүй тохиолдолд шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

3.3. “А” дансанд “Мал бүхий өрх”-өөр бүртгэгдсэн өрхийн тэргүүний тухайн хугацаанд сайн дураар даатгуулсан эсхүл Ажилласан жил, тэтгэврийн даатгалын

шимтгэлийг нөхөн тооцох тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн хугацааг малчнаар ажиллаж, шимтгэл төлснөөр тооцно. Харин мал бүхий өрхийн бусад гишүүнийг малчинд хамааруулахгүй бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан хугацааг нийт шимтгэл төлж ажилласан хугацаанд нь оруулан тооцно.

Санамж³.Энэ тохиолдолд өрхийн тэргүүн малчнаас өөр ажил хөдөлмөр эрхэлсэн бол малчинд хамааруулахгүй.

3.4.Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.1 дэх хэсэгт заасны дагуу 15 нас хүрсэн өдрөөс эхлэн тооцно.

3.5.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.8 дахь заалтад цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэнийг тэтгэврийн, тэтгэмжийн даатгалд албан журмаар даатгуулахаар, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.17 дахь хэсэгт “Энэ хуулийн 7.4.8-д заасан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр тооцож, улсын төсвөөс нийгмийн даатгалын зохих санд улирал бүр төлнө” гэж тус тус заасан тул цаатан иргэний тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгдсөн хугацааг малчнаар ажилласнаар тооцно.

Санамж⁴.Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар уг хуулийн 1/4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт цаа буга маллан тайгад амьдарч байгаа цаатан иргэнийг тэтгэврийн, тэтгэмжийн даатгалд төрөөс даатгуулахаар зохицуулсан тул цаатан иргэний 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хугацааг малчнаар ажилласнаар тооцно.

3.6.Цаатан иргэний 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө малчнаар ажилласан хугацааг тодорхойлохдоо энэ зааврын 4.2 дахь хэсэгт зааснаар тооцно.

Дөрөв. Даатгуулагчийн малчнаар ажилласан хугацаанд хамаарахгүй хугацаа

4.1.Дараах хугацааг даатгуулагчийн малчнаар ажилласан хугацаанд хамааруулахгүй. Үүнд:

4.1.1.Цэргийн алба хаасан хугацаа;

4.1.2.Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежид болон бусад сургуульд суралцсан хугацаа;

4.1.3.”А” дансанд малчнаар бүртгэгдсэн боловч малчнаас өөр ажил хөдөлмөр эрхэлсэн хугацаа;

4.1.4.”А” дансанд тухайн өрхийн малчдын мэдээлэлд бүртгэгдээгүй иргэний мал малласан хугацаа;

4.1.5.1995 оноос хойш нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй боловч малчнаар ажилласныг шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацаа;

4.1.6.”А” дансанд “Бусад өрх” болон “Тавиул малын эзэн өрх”-өөр бүртгэгдсэн хугацаа;

4.1.7.Гадаад оронд амьдарсан хугацаа зэрэг болно.

4.2.Даатгуулагчийн шимтгэл төлж, ажилласан хугацаа нь энэ зааврын 2 дахь хэсэгт заасан баримт бичгээр нотлогдохгүй тохиолдолд уг хугацааг малчнаар ажилласан хугацаанд тооцохгүй, харин шимтгэл төлж ажилласан нийт хугацаанд нь оруулан тооцно.

4.3. Даатгуулагчийн малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаатай нэгтгэн тооцож хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэр тогтоохгүй.

Тав. Бусад

5.1. Даатгуулагчийн 1995 он ба түүнээс хойш малчнаар ажилласныг нотлох “А” дансны лавлагаа, энэ зааврын 2.3-т заасан баримт бичиг байхгүй тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх төв болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх сал зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) хуралдаанаар хэлэлцэж даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тодорхойлсон тогтоол гаргана.

5.2. Төв болон салбар зөвлөл нь даатгуулагчийн 1995 он ба түүнээс хойш нийгмийн даатгалын шимтгэл төлсөн боловч мал малласан нь “А” дансаар нотлогдохгүй хугацааг тодорхойлохдоо даатгуулагчаас дараах баримт бичгээс аль бүрдүүлэх боломжтойг нь гаргуулж малчнаар ажилласан хугацааг тодорхойлоход үндэслэнэ. Үүнд:

- 5.2.1. Малын хөлийн татвар төлсөн баримт;
- 5.2.2. Арьс, шир, ноосны урамшуулал авсан баримт;
- 5.2.3. “Малчин” мэргэжлийн үнэмлэх;
- 5.2.4. Шагнуулсан баярын бичиг, жуух бичиг, фото зураг;
- 5.2.5. Тухайн малчны талаар сонин, хэвлэлд нийтлэгдсэн нийтлэл;
- 5.2.6. Мал тооллоготой холбоотой баримт бичиг;
- 5.2.7. Бэлчээр ашигласны татварын баримт;
- 5.2.8. Өвөлжөө, хаваржаа, хадлангийн газрын гэрчилгээ;
- 5.2.9. Даатгуулагч эхийн хүүхдээ төрүүлсэн эмнэлгийн тухайн эхийг малчнаар бүртгэсэн бүртгэл;
- 5.2.10. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн эцэг, эхийг нь малчнаар бүртгэсэн хувийн хэрэг;
- 5.2.11. Сургуулийн хүүхдийн дотуур байрны хоолны төлбөрийг малаар болон мөнгөөр төлсөн баримт;
- 5.2.12. “А” данс нь байхгүй оны өмнөх болон дараагийн оны “А” дансны лавлагаа;
- 5.2.13. Тухайн аймаг, дүүрэг, сум, баг, хорооны “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн жил бүрийн бүртгэлийн лавлагаа;
- 5.2.14. Малчнаар ажилласныг тогтоосон шүүхийн шийдвэр зэрэг болно.

5.3. Зөвлөл нь даатгуулагчийн “А” дансгүй мал малласан хугацааг нь энэ зааврын 5.2-т заасан баримт бичгийг үндэслэн доор дурдсанаар тодорхойлно:

5.3.1. Энэ зааврын 5.2.1, 5.2.2, 5.2.7, 5.2.8, 5.2.11-д заасан татвар, урамшуулал, төлбөр төлсөн баримтад бичигдсэн тухайн онд 1 жил малчнаар ажилласнаар тооцно.

Санамж⁵. Жишээ нь, даатгуулагч 1995-2000 он бүрт малын хөлийн татвар төлсөн нь архивын баримтаар нотлогдсон бол 6 жил, эсхүл зарим онд буюу 1995, 1198 онд татвар төлсөн нь баримтаар нотлогдсон бол 2 жил малчнаар ажилласнаар тооцно.

5.3.2. Энэ зааврын 5.2.3, 5.2.4, 5.2.5, 5.2.6, 5.2.9, 5.2.10, 5.2.12, 5.2.13-т заасан баримт бичигт бичигдсэн тухайн онд малчнаар ажилласан гэж үзнэ.

Санамж⁶. Жишээ нь, ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн 1998 оны хувийн хэрэгт эцэг, эхийг нь малчнаар бичсэн бол эцэг, эсхүл эхийг нь 1998 онд 1 жил малчнаар ажилласнаар тооцно.

Санамж⁷. Жишээ нь даатгуулагчийн 1999 оны “А” дансны лавлагаа байхгүй тохиолдолд 1998, 2000 оны “А” дансны лавлагааг үндэслэн 1999 оныг малчнаар ажилласнаар тооцно.

5.4. Төв болон салбар зөвлөл нь даатгуулагчийн “А” дансгүй онууд нь энэ зааврын 5.2-т заасан баримт бичгээр нотлогдохгүй тохиолдолд ямар нэгэн нотлох баримт бичиггүйгээр малчнаар ажилласан хугацааг тодорхойлохгүй.

Зургаа. Даатгуулагчид малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоох

6.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад заасан нөхцөлийг хангасан даатгуулагчид малчны нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтооно.

6.2. Энэ зааврын 6.1-д заасан нөхцөлийг хангасан даатгуулагчид өндөр насны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос мөн хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан тэтгэвэр бодох аргаар, мөн хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан хугацаанд тогтоож, олгоно.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Аймаг, сумын архивын хэлтэс, тасгаас гаргасан “А” дансны лавлагааны үндэслэлийг аймаг, дүүрэг, сумын нийгмийн даатгалын байцаагч архивын эх баримттай тулган баталгаажуулна.

7.2. Нийгмийн даатгалын байгууллага нь хууль тогтоомжийн хүрээнд иргэд, даатгуулагч, малчдад түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж, тэдгээрийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана.

7.3. Энэ зааврыг зөрчсөн тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.